

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

2025 оны ... дугаар сарын ...

“НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ” УТҮГ-ЫН 2025-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

“НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ
АВТО БААЗ”-ЫН УТҮГ-ЫН ДАРГА



Э.БОЛОР-ЭРДЭНЭ

Улаанбаатар хот,
2025 он

НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТҮГ



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024-2028 ОН

АГУУЛГА

Нэг.Нийтлэг үндэслэл.....	2
Хоёр.Мандатын шинжилгээ.....	7
Гурав.Алсын хараа.....	7
Дөрөв.Эрхэм зорилго.....	7
Тав.Орчны шинжилгээ.....	9
Зургаа.Байгууллагын засаглалын шинэчлэлийн бодлогын хүрээ.....	12
Долоо.Байгууллагын засаглалын өнөөгийн төлөв байдал	20
Найм.2024-2028 оны Стратегийн төлөвлөгөөний засаглалын шинэчлэлийн 6 зорилтын хэрэгжилтийн ерөнхий бүтэц.....	22

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт зааснаар “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж тусгасан. Уг заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам” болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал” тус тус батлагдсан. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын “Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын дэд систем”-ийг ашиглалтад оруулах чиглэл бүхий Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 03/1219 тоот албан бичгийн хүрээнд 2024 оны 01 сарын 02-ны өдрөөс 2028 оны 12 сарын 31-ний өдрөөр байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулж, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, байгууллагын хөгжлийн чиг хандлага, санхүү, хүний нөөц, техник, технологийн бодлогыг тодорхойлох шаардлага үүсч байна.

Энэ нь төрийн байгууллагуудын тээврийн хэрэгслийн хэрэгцээ өсөн нэмэгдэж, илүү байгальд ээлтэй чанар, шуурхай байдал, аюулгүй байдлыг шаарддаг болсонтой шууд холбоотой. Иймд хүний нөөцийн чадавх, үйл ажиллагааны зохион байгуулалтад шинэчлэл хийх замаар бүтээмжийг нэмэгдүүлэх, зам тээврийн ослын эрсдэлийг бууруулах, засвар үйлчилгээг шуурхай болгох, хяналт-шинжилгээний систем нэвтрүүлэх зэрэг асуудлуудыг системтэйгээр шийдвэрлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөтэй уялдуулан Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг шинээр боловсруулж байна.

Түүнчлэн тээврийн хэрэгслийн элэгдэл, засвар үйлчилгээний зардал өсөх, шатахуун болон сэлбэг хэрэгслийн үнэ хэлбэлзэх, мөн хүний хүчин зүйлээс үүдэх эрсдэлүүдийг урьдчилан тооцоолсон удирдлагын системтэй болох нь стратеги төлөвлөгөө боловсруулах чухал үндэслэл болж байна.

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ нь стратеги төлөвлөгөө нь хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хүрээнд байгууллагын хөгжлийн стратегийг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлоход оршино.

ХОЁР.МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны 1974 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 08 тоот тогтоолоор Хотын АДХ-ын Гүйцэтгэх

захиргааны шууд харьяа газар, хэлтсүүдийн жижүүр, дуудлага үйлчилгээний авто машиныг нэгтгэн Сангийн Яамнаас баталсан төсвийн дагуу хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны харьяанд хөнгөн тэрэгний гражийн зориулалтаар анх байгуулагдсан.

Нийслэлийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/995 захирамжаар 3 хэлтэс, 105 ажилтан, албан хаагчтай болон өргөжиж, тус захирамжаар шинэчлэгдсэн байгууллагын дүрмийг мөрдлөг болгон ажиллаж байна.

НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТҮГ-ЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАГВАР

Зураг 1




Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ нь Нийслэлийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон Нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг

хэрэгжүүлэх, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, хэрэгжүүлэгч агентлагууд, газар, албадын ажил үйлчилгээнд авто машинаар үйлчлэхэд тусгагдсан бодлого, удирдамжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Нийслэлийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газар мөн.

НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТҮГ-ЫН ХОЛБОГДОГЧ ТАЛУУД

Зураг 2



ХОЛБОГДОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО

Хүснэгт 1

Холбогдогч талууд	Оролцоо					
	Мэдээлэх	Зөвлөх, эргэх холбоогоор хангах	Санал өгөх	Хамтран ажиллах	Шийдвэр гаргах	Хяналт тавих
Зам, тээвэр хөгжлийн яам	✓	✓	✓	✓	✓	✓
Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	✓	✓	✓	✓	✓	✓
Засаг даргын тамгын газар	✓	✓	✓	✓	✓	✓

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	✓	✓	✓	✓		
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	✓	✓	✓	✓		
НЗДХА-Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд	✓	✓	✓	✓		
Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагууд	✓	✓	✓	✓		
Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	✓	✓	✓	✓		
Дүүргийн Засаг даргын тамгын газар	✓	✓	✓	✓		

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын чиг үүрэг, үйл ажиллагааг зохицуулсан 23 орчим эрх зүйн баримт бичиг үүнээс 4 салбарын эрх зүйн баримт бичиг байна. Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын чиг үүргийг хууль эрх зүйн орчинд “ерөнхий чиг үүрэг 2, үндсэн чиг үүрэг 10” гэж ангилж байна. Хүснэгтээр дэлгэрэнгүй харуулав.

МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ хүснэгт 2

№	Үндсэн чиг үүрэг	Хуулийн нэр, заалт	Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч нэгжийн нэр	
			Үндсэн хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч
Ерөнхий чиг үүрэг-1: Стандартад нийцсэн тээврийн хэрэгслийн үйлчилгээг хүргэх				
1.1	Тээврийн хэрэгслийн захиалгын үйлчилгээ	Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль 9 дүгээр зүйл 9.1.3	Тээвэр зохицуулалтын хэлтэс	Бусад хэлтэс
1.2	Тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ	Авто тээврийн тухай хууль 7 дугаар зүйл 7.1.1	Тээвэр зохицуулалтын хэлтэс	Бусад хэлтэс
1.3	Цахим, ногоон тээврийн бодлого хэрэгжүүлэх	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 4 дүгээр зүйл 4.1.4	Бүх хэлтэс	-
Ерөнхий чиг үүрэг-2: Төрийн үйлчилгээг тасралтгүй, чанартай явуулах				

2.1	Үйлчилгээний үр ашиг, байгууллагын бүтэц зохион байгуулалт	Төрийн албаны тухай хууль 13 дугаар зүйл 13.1.3	Бүх хэлтэс	-
2.2	Албан хэрэгцээний тээврийн тасралтгүй, найдвартай үйлчилгээ	Автотээврийн тухай хууль 7 дугаар зүйл 7.1.3	Тээвэр зохицуулалтын хэлтэс	Бусад хэлтэс
2.3	Төрийн өмчийн үр ашигтай, ил тод, хариуцлагатай менежмент	Төсвийн тухай хууль 8 дугаар зүйл 8.1.2	Бүх хэлтэс	-
2.4	Мэргэшсэн, ёс зүй, сахилга баттай албан хаагчдыг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах	Төрийн албаны тухай хууль 10, 15 дугаар зүйл	Захиргаа хүний нөөцийн хэлтэс	Бусад хэлтэс
2.5	Хууль тогтоомж, дээд газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих	Төрийн албаны тухай хууль 22 дугаар зүйл 22.1.5, 22.1.7	Захиргаа хүний нөөцийн хэлтэс	Бусад хэлтэс
2.6	Дотоод хяналт шалгалт	Төсвийн тухай хууль 26 дугаар зүйл	Захиргаа хүний нөөцийн хэлтэс	Бусад хэлтэс

Мандатын хэрэгжилтэд эрх зүйн орчин чиг үүрэг тодорхой, 50 жилийн ажлын туршлага, төсвийн санхүүжилт, дэвшилтэт технологид шилжих боломжтой зэрэг давуу талууд байгаа ч эрх зүйн орчны шинэчлэл, тээврийн хэрэгслийн насжилт өндөр, үүнийг дагаад урсгал болон гэнэтийн засвар үйлчилгээний зардал өндөр, шатахуун, сэлбэг хэрэгслийн үнийн нэмэгдэл, хяналтын систем болон хүний нөөц дутмаг зэрэг сул талууд тулгарч байна.

Иймд төрийн үйлчилгээг шуурхай, аюулгүй, үр ашигтай хүргэхэд чиглэгдсэн эрх зүйн шинэчлэл, техник, хүний нөөцийн чадавхыг стратегийн төлөвлөгөөнд тусгаж эдгээр асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлэхэд чиглэх нь зүйтэй.

ГУРАВ.АЛСЫН ХАРАА

Бид Нийслэлийн төрийн үйлчилгээний шилдэг үйлчилгээг хүргэгч, хэрэглэгчдийн сэтгэл ханамжаар манлайлсан байгууллага болно.

ДӨРӨВ.ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид нэгдмэл багаар тэргүүлж, төрийн тээврийн үйлчилгээг шуурхай, аюулгүй, хариуцлагатай, тасралтгүй хангах замаар тогтвортой хөгжлийг дэмжинэ.

ҮНЭТ ЗҮЙЛ

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТУГ-ын үйл ажиллагааны суурь зарчим нь ажилтнуудын ёс зүй, технологийн дэвшил, төрийн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг илэрхийлнэ. Стратегийн төлөвлөлт, гүйцэтгэл, байгууллагын хөгжилд чиг баримжаа болж тогтвортой хөгжих гарц болдог.

- Хариуцлага хандлага– Төрийн үйлчилгээний чанар, найдвартай байдлыг хангасан, ёс зүйтэй харилцаа.
- Аюулгүй байдал – Замын хөдөлгөөний болон ажилтан, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих.
- Шударга байдал – Ил тод, тэгш, хууль ёсны шийдвэр гаргалт, хяналт шинжилгээ.
- Шуурхай байдал – Түргэн, найдвартай үйлчилгээ үзүүлэх.
- Байгаль орчинд ээлтэй хандлага – Тээврийн үйл ажиллагаанд ногоон технологийг дэмжиж, стандартыг нэвтрүүлэх.
- Мэргэжлийн ур чадвар – Хүний нөөцийн тасралтгүй хөгжил, мэргэшил.
- Технологид суурилсан үйлчилгээ – Цахим, ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах.

ТАВ.ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Хүний нөөцийн шинжилгээ: Удирдлагын манлайлал сайтай, мэргэжлийн баг хамт олныг бүрдүүлэн ажилладаг. 3 хэлтэс, 105 ажилтан, албан хаагчтайгаас захиргааны 10 ажилтан, 90 инженер техникийн ажилтан (үүнд үйлчилгээний жолооч хамаарна) , 5 аж ахуйн ажилтантай. Захиргааны албан хаагчид бүгд дээд боловсролтой мэргэжлээрээ ажилладаг. Байгууллагын хүний нөөцийн хувьд мэргэжлийн мэргэшсэн боловсон хүчин нийт ажилтан, албан хаагчдын 40%-өөс 50%-ийг эзэлдэг. Цалин хөдөлмөрийн хөлс(ТУ-3) нь зах зээлийн үнийн өсөлттэй харьцуулахад харьцангуй бага тул үйлчилгээний жолооч нарын хомсдол, ажлаас чөлөөлөгдөх гол шалтгаан болдог. Эрүүл аюулгүй орчинд тухтай ажиллах нөхцөлийг сайжруулж, ажилтнуудын нийгмийн баталгааг хангаснаар тогтвор суурьшилтай, сэтгэл ханамж өндөр ажиллах боломж нэмэгдэж байна. Хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг ил тод явуулдаг. Мэргэжил сургалтын үндэсний төвтэй хамтран ажиллах боломжтой.

Санхүүгийн шинжилгээ: 2024 оны байдлаар санхүүгийн хувьд тогтвортой, хэмнэлтийн горимд шилжсэн байдалтай. Нийслэлийн болон харьяа агентлагуудтай “Дуудлагын автомашинаар үйлчлэх гэрээ”-ний дагуу үйлчилгээ үзүүлж, ажлын гүйцэтгэлд хяналт тавин хамтран ажиллаж байна. Бодит үр ашгаа нэмэгдүүлэх эрх мэдэл хязгаарлагдмал, тулгамдаж байгаа асуудлаа бие даан шийдвэрлэх боломжгүй.

Техникийн шинжилгээ: Нийслэлийн хөрөнгө оруулалтаар сүүлийн үеийн техник, технологийг нэвтрүүлэх зорилгоор авто машины гараашийг давхар зогсоолтой болгон паркыг тоноглогсноор 44 авто машин багтдаг дулаан зогсоол нь багадаа 80 автомашин байрлуулж болох нь мэргэжлийн байгууллагаас гаргасан техникийн нөхцөл, ижил төстэй байгууллагын хийсэн туршлагаас харагдаж байна. Иймд өөрийн байгууллагад хэрэгжүүлэх нь чухал асуудал болоод байна. Байгууллага 86 авто машинтай бөгөөд 40 авто машин 3-9 жилийн насжилттай, 46 авто машин 10-аас дээш жилийн насжилттай байна. Энэ нь 2024 онд парк шинэчлэлт хийх нэн шаардлагатай байгааг харуулж

байна. Байгууллагын авто машины угаалгад саарал ус ашиглах боломжтой ба байгаль орчинд үзүүлэх эерэг нөлөөллүүд их.

Хүснэгт 3 ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ НЭГТГЭХ СВОТ

Дотоод орчин	
<u>Давуу тал</u> -Хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй шуурхай эргэлтэд орох боломжтой. -Байгууллагын гадаад харилцаа, туршлага арвин. -Өөрийн байртай. Гарааш, угаалга, засварын цех. -Төсвөөс санхүүждэг. -Үйл ажиллагааны орлоготой. -Хууль эрх зүйн орчинд үйл ажиллагаагаа явуулдаг.	<u>Сул тал</u> -Мэргэжлийн өвчлөл (үйлчилгээний жолооч нарт нурууны суулт, өвдөгний өвчлөл үүсдэг.) -Байгууллагын оффисын болон оффисын бус ажилчид нь тээврийн хэрэгслээс ялгарах утаа, тооцоноороо амьсгалдаг. -Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалин хөлс бага тул хүний нөөцийн хомсдолд дулааны улиралд ордог. -Тээврийн хэрэгслүүдийн насжилт өндөр тул урсгал зардал их гардаг. -Хэрэглэгч байгууллагуудын ажлын ачааллаас хамаарч жолооч нар илүү цагаар ажилладаг. -Нийслэлээс зохион байгуулдаг сургалт хөтөлбөрт байгууллагын онцлогоос хамааран оролцох боломж хомс. -Хадгалалт, хамгаалалтын шаардлага хангах тээврийн хэрэгслийн зогсоол муу. -Саарал ус ашиглах технологи нэвтрээгүй тул усны хэмнэлт хийх боломжгүй. -Дэвшилтэд технологи нэвтрүүлэх шаардлагатай.
Гадаад орчин	
<u>Боломж</u> -НЗД, НИТХ, НЗДТГ, түүний харьяа агентлаг, газар, албадуудтай шууд харилцан дэмжлэг авах. -Бусад төрийн байгууллагын тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээ, оношилгоо хийх. -Байгальд ээлтэй технологийг нэвтрүүлэх боломжтой.	<u>Эрсдэл</u> -Шатахуун, сэлбэг, агрегат гааль, татварын үнийн өсөлт нь үйл ажиллагааны зардал нөлөөлөн өл үүсдэг. -Хууль эрх зүйн хязгаарлалтын өөрчлөлт их тул төлөвлөгөөний хэрэгжилт удаашрах, зогсох, биелэгдэхгүй байх эрсдэл учирдаг. -Тээврийн хэрэгслийн хүрэлцээ муу, он хуучин автомашинууд их тул эвдрэл гэмт нэмэгдэж байдаг.

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, хүний нөөцийн чадавх, техник технологийн хөгжил, бодлогын уялдаа зэрэг хүчин зүйлс нь байгууллагын засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Засаглалын шинэчлэл нь байгууллагын ил тод, хариуцлагатай, үр ашигтай, тогтвортой, төрийн үйл ажиллагааг бүтээмжтэй хэрэгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэнэ.

Иймд засаглалын шинэчлэлийн дараах зургаан үндсэн зарчмын хүрээнд стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1. үйлчилгээний чанар ба аюулгүй байдлыг сайжруулах;**
- 2. цахим засаглал, ухаалаг хяналтын тогтолцоог хөгжүүлэх;**
- 3. авто парк, техник тоног төхөөрөмж, ногоон шийдэлд шилжих;**
- 4. хүний нөөцийн чадавх ба ёс зүйг бэхжүүлэх;**
- 5. эрсдэл, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох;**
- 6. тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх.**

1. Үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын гол чиг үүрэг нь төрийн албан хаагчдад найдвартай хурдан, стандартад нийцсэн тээврийн үйлчилгээ үзүүлэхэд оршдог.

Манай байгууллага 86 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлдэг бөгөөд нийт тээврийн хэрэгслийн 53,5% буюу 46 тээврийн хэрэгслийн насжилт өндөр. Энэ нь үйлчилгээний чанар, аюулгүй байдалд эрсдэл дагуулсаар байна. Гэсэн хэдий ч бид тээврийн хэрэгслүүдийн ТҮ-н засвар үйлчилгээг тогтмол хийж, өөрийн засварын цехийн нөөц боломжийг бүрэн ашиглан үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйлчилгээний чанар нь зөвхөн тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал бус хүртээмж, цагийн нарийн зохицуулалт, үйлчилгээний жолоочийн харилцаа, хэрэглэгчийн гомдол санал зэрэг олон үзүүлэлтүүдээр хэмжигдэж байдаг.

Үйлчилгээний стандартыг шинэчлэн үйлчилгээний жолооч, техникийн ажилтнуудад тогтмол зааварчилгаа, сургалт мэдээлэл хүргэж, байгууллагын бүх шатны ажилтан, албан тушаалтанд мөрдүүлэн хэвших нэн шаардлагатай.

Түүнчлэн хэрэглэгч байгууллагуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч, дүн шинжилгээ хийн тасралтгүй сайжруулж, ирсэн гомдол, санал хүсэлтийг хянах цахим платформ хөгжүүлэх нь чухал юм. Мөн үйлчилгээний KPI-г (хугацаа, зөрчилгүй явсан км, хэрэглэгчийн үнэлгээ г.м) тогтоосноор хэрэглэгчийн сэтгэл ханамж, хүртээмж, бүтээмж нэмэгдэж, цаашлаад төрийн үйлчилгээний итгэл нэмэгдэнэ.

2. Цахим засаглал, ухаалаг хяналтын тогтолцоог хөгжүүлэх

Цахим засаглал, ухаалаг хяналтын тогтолцоог хөгжүүлэх нь өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт ил тод, ухаалаг удирдлагын систем бүхий цахим үйл ажиллагааг төлөвшүүлэхэд чиглэнэ.

Манай байгууллага цахим засаглалын шийдлүүдийг нэвтрүүлснээр хэрэглэгчид цаг хугацаа хэмнэхээс гадна удирдлага ч бодит мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах боломжтой болно. Мөн хүнд суртал, авлигын эрсдэл буурах, цахилгаан тээврийн хэрэгслийн менежмент сайжрах суурь тавигдана.

Өнөөдрийн байдлаар бид нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын “UB ERP” системийн “Дуудлагын автомашины захиалгын систем” дэд системийг нэвтрүүлэн, тээврийн хэрэгслийн захиалгыг хүлээн авч, үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Энэ нь төрийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн бодит хэрэгцээ шаардлагыг харуулах, ажлын цаг хэмнэх, түгжрэл бууруулахад тодорхой хувь нэмэр оруулдаг.

Автомашин бүрд байршил, түлш, ашиглалтын ухаалаг хяналтын төхөөрөмж суурилуулах, цахилгаан, хайбрид автомашины оношилгооны төхөөрөмж, дагалдах программ хангамж ашиглах боломжийг бүрдүүлж өгснөөр эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, цаашлаад байгальд ээлтэй, стандартад нийцсэн цахилгаан тээврийн хэрэгслийн хэрэглээг төрийн үйлчилгээнд бүрэн нэвтрүүлэх алхам болно.

Мөн цахим тайлангийн систем, хяналтын dashboard боловсруулснаар өгөгдөлд суурилсан удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, шийдвэр гаргалтыг хурдасгах, авто паркийн ухаалаг хяналтын тогтолцоог хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

3. Авто парк, техник тоног төхөөрөмж, ногоон шийдэлд шилжих

Нийслэлийн төр захиргааны авто бааз нь өдөр бүр 80 гаруй тээврийн хэрэгслээр төрийн үйлчилгээг тасралтгүй хангаж байгаа хэдий ч өмнө дурдсанчлан насжилт өндөр тээврийн хэрэгслүүдийн шатахуун зарцуулалт өдрөөс өдөрт нэмэгдэж байна. Сүүлийн жилүүдэд шатахууны үнийн хэлбэлзэл, хуучин техник хэрэгслээс үүдэлтэй засвар үйлчилгээний зардал өсч, байгаль орчны бохирдлын нөлөө ихэссэн нь тээврийн зардлыг нэмэгдүүлж, үр ашиг буурахад хүргэж байна.

Энэ нөхцөл байдал нь зөвхөн байгууллагын төсөв, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, чиг үүргийн дагуу төрийн үйлчилгээг хүргэх чанар, хүртээмжийг алдагдуулах эрсдэлтэй. Иймд шатахуун болон сэлбэгийн зардлыг оновчтой хэмнэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, байгаль орчинд ээлтэй, тогтвортой ногоон шийдэл бүхий техник технологийг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Энэ нь тээврийн үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлж, шатахуун зарцуулалтыг бууруулахаас гадна төрийн төсвийн хэмнэлтэд шууд нөлөөлнө.

Түүнчлэн саарал ус, нарны эрчим хүч ашигласан угаалгын цех бүхий техник технологийн дэвшлийг хөгжүүлж, тээврийн хэрэгслийн өргөх буулгах лифттэй, цахилгаан болон гибрид авто машин оношилгооны төвтэй паркийг ашиглалтад оруулах асуудал тавигдана.

4. Хүний нөөцийн чадавх ба ёс зүйг бэхжүүлэх

Ажилтны чадавх бол төрийн байгууллагын үйлчилгээний чанар, нэр хүнд, төрийн итгэлийн үндэс юм. Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ нь 78 үйлчилгээний жолоочтой бөгөөд тэдний ажил мэргэжлийн ур чадвар, аюулгүй

ажиллагаа, замын хөдөлгөөний дүрэм, тээврийн стандартын мэдлэг, ёс зүйн хандлага зэргээс үйлчилгээний чанар шууд хамаарна.

Байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамааран үйлчилгээний жолооч нарыг танхимын болон практик сургалтад хамруулах нөхцөл хязгаарлагдмал, дээд газраас салбарын чиглэлийн сургалт зохион байгуулдаггүй зэрэг асуудлууд тулгарсаар байдаг.

Иймд үйлчилгээний жолооч, техникийн ажилчдад тусгайлан зориулсан мэргэжлийн сургалтын хөтөлбөр боловсруулах, ёс зүйн сургалт, стандарт тогтоох шаардлагатай. Мөн гүйцэтгэлд суурилсан урамшууллын системийг хөгжүүлэх, нийгмийн баталгаа, сэтгэл зүйн аюулгүй байдал, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэхээр оролцогч талуудын оролцоонд суурилсан тогтвортой, хамтын засаглалыг хөгжүүлэх нь ажилчдын сэтгэл ханамжийг дээшлүүлж, тогтвор суурьшилтай, хариуцлагатай ажиллах нөлөөг нэмэгдүүлнэ.

5. Эрсдэл, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох

Байгууллагын үйл ажиллагаанд үүсч болзошгүй эрсдэлийг урьдчилан илрүүлэх, бууруулах, тасралтгүй хяналт-шинжилгээ хийж, дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох замаар байгууллагын үр ашиг, ил тод байдлыг дээшлүүлэхэд чиглэнэ.

Нийслэлийн Төр захиргааны авто баазын тасралтгүй, аюулгүй, үр ашигтай үйл ажиллагааг хангахын тулд байгууллагын дотоод үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэлийг урьдчилан илрүүлж, бууруулах, хяналт-шинжилгээний цахим, ухаалаг тогтолцоог бүрдүүлэн, ил тод байдал, хариуцлагыг төлөвшүүлэх шаардлагатай.

Манай байгууллагын хувьд эрсдэл үүсч болзошгүй нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг дараах байдлаар тодорхойллоо.

- Өндөр эрчимтэй үйлчилгээ: Өдөр бүр 70–80 автомашин төрийн байгууллагуудад тээврийн үйлчилгээ үзүүлдэг. Энэ нь техникийн эвдрэл, хүний алдаа, зардлын өсөлт, хариуцлагын тодорхойгүй байдал зэрэг эрсдэл дагуулдаг.
- Техникийн насжилт: Автомашины 50 гаруй хувь нь насжилт өндөртэй, эвдрэл гэмтэл гаргах магадлал их, засвар үйлчилгээний зардал өндөр байна.
- Шатахууны хяналтгүй зарцуулалт: Түлшний хяналтын систем хангалтгүй, зардал өсөх шалтгаан болж байна.
- Хүний хүчин зүйл: Жолоочийн сахилга бат, хөдөлмөрийн аюулгүй байдал, тээврийн хуваарь мөрдөх байдал сул.
- Мэдээллийн хамгаалалт: GPS, цахим захиалга зэрэг мэдээллийн аюулгүй байдлыг хангах нэгдсэн систем байхгүй.

Эдгээрээс харахад байгууллагын шинэчлэл, ил тод байдал, хариуцлагыг бэхжүүлэх зорилгоор инновац, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалт, ухаалаг хяналтын систем нэвтрүүлэх замаар эрсдэлийг удирдах, дотоод хяналтыг байгууллагын үнэт соёлын нэг хэсэг болгон үйл ажиллагаандаа хэвшүүлэх нь цаашдын тогтвортой хөгжлийн үндэс болно.

Нийслэлийн Төр захиргааны авто бааз нь төрийн тээврийн үйлчилгээг өдөр тутам тасралтгүй, аюулгүй, үр ашигтай хүргэх үүрэгтэй. Тиймээс үйл ажиллагааны явцад үүсч болзошгүй эрсдэлийг урьдчилан илрүүлэх, бууруулах, тасралтгүй хяналт-шинжилгээ хийх, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах нь чухал ач холбогдолтой юм.

6.Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх

Нийслэлийн Төр захиргааны авто бааз нь төрийн байгууллагуудад тээврийн үйлчилгээ үзүүлдэг, төсвөөс санхүүждэг байгууллага учир тогтвортой хөгжил, хариуцлагатай засаглал, үр ашигтай менежмент нь байгууллагын үйл ажиллагааны гол үнэт зүйл байх ёстой. Тиймээс энэхүү бодлого нь байгууллагын засаглалыг шинэчлэн сайжруулах, үйл ажиллагааг ил тод, үр ашигтай, ногоон болон цахим шилжилтэд нийцтэй болгоход чиглэнэ.

Байгууллагын засаглалын тогтолцоог тогтвортой хөгжлийн зарчимд нийцүүлэн шинэчилж, нээлттэй, хариуцлагатай, цахимжсан, байгальд ээлтэй, хүний нөөцийн чадавхад тулгуурласан удирдлагын соёлыг төлөвшүүлэхэд зорино.

Стратеги төлөвлөгөөний зорилтууд SMART шалгуурыг хангасан, KPI үзүүлэлтүүдийг байгууллагын онцлогт тохируулан боловсруулсан, тооцоо шинжилгээнд тулгуурлан гаргасан бол байгууллагын хөгжлийн чиглэл, хүрэх зорилгын үр дүнг бодит болгоход ихээхэн нөлөөлнө. Түүнчлэн байгууллагын удирдлагын шийдвэр гаргалт, бодлого төлөвлөлт тодорхой болдог.

Дээрх стратегийн үндсэн 6 зорилгод тулгуурлан Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын урт хугацааны зорилтуудыг тодорхойлон Төрийн тээврийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, аюулгүй, цахим системд суурилсан, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлсэн мэргэшсэн авто бааз болно гэдэгт итгэлтэй байна.

ДОЛОО. БАЙГУУЛЛАГЫН ЗАСАГЛАЛЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Байгууллагын үүсэл

Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны 1974 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 08 тоот тогтоолоор Хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны шууд харьяа газар, хэлтсүүдийн жижүүр, дуудлага үйлчилгээний авто машиныг нэгтгэн Сангийн Яамнаас баталсан төсвийн дагуу хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны харьяанд хөнгөн тэрэгний авто паркийн зориулалтаар анх байгуулагдаж 1992 онд АДХГЗ-ны 23 дугаар тогтоолоор 46 автомашин хөдлөх бүрэлдэхүүнтэйгээр Улаанбаатар хотын АДХГЗ-ны Авто бааз нэртэй, 1994 оноос Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын авто бааз, 2007 оны 07 дугаар сараас Нийслэлийн төр захиргааны авто бааз нэртэйгээр нийслэлийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газар болон өргөжиж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагууд, Захирагчийн ажлын алба, нийслэлийн харьяа байгууллагуудад автомашинаар үйлчлэх зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ үүсэн байгуулагдсаны түүхт 50 жилийн ойгоор Нийслэлийн Иргэдийн

төлөөлөгчдийн хурлын даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/02 дугаар захирамжаар Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ нь "Хангарди" одонгоор шагнуулсан.

Үйлчилгээний чанар ба аюулгүй байдал

Үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөв байдал нь манай байгууллагын гол үзүүлэлт бөгөөд жил бүр нийт тээврийн хэрэгсэлд хийгддэг засвар үйлчилгээ, татвар, даатгал, оношилгооны мэдээллийг өмнөх оны байдлаар хүргэлээ. Тээврийн хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр авто зам ашигласны төлбөр хураах талаар авах зарим арга хэмжээний тухай Нийслэлийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэн хуулийн хугацаанд холбогдох дансанд төвлөрүүлэн ажилласан. 2025 онд Тээврийн хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр авто зам ашигласны төлбөр нэмэгдсэнтэй холбоотойгоор гарах зардал 3 дахин өсөж байна. Энэ нь байгууллагын хувьд санхүүгийн хүндрэл үүсэх шалтгаануудын нэг болоод байна.

Жил бүр тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, үйлчилгээнд анхаарч төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засвар үйлчилгээ хийдэг. Үүнд:

- Улсын техникийн хяналтын үзлэг оношилгоо.
- ТҮ-1, ТҮ-2 үйлчилгээгээр тээврийн хэрэгслийн тос масло, агаар, салоны болон моторын шүүрийг солих.
- Тээврийн хэрэгслийн салоны өнгөлгөө.
- Иж бүрдэл.
- Өвөл зуны дугуй.
- Дриллэн өнгөлгөө.
- Бусад

Эдгээр засвар үйлчилгээг өөрийн засварын цехэд 100% хийж гүйцэтгэдэг. 2024 онд засвар үйлчилгээний тоног төхөөрөмжийг MNS 4598:2011 стандартын дагуу бүрэн ажилд оруулж, өөрсдийн нөөц боломжоор засвар үйлчилгээг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх боломжтой болсон. Төлөвлөгөөт бус засварт 2023 онд 158 тээврийн хэрэгсэл орсон бол 2024 онд давхардсан тоогоор 259 тээврийн хэрэгсэл орсон байна. Энэ нь хуучин тээврийн хэрэгслийн элэгдэл ихсэж засварын зардал жилээс жилд нэмэгдэн, санхүүгийн хувьд хүндрэл үзүүлэх шалтгаан болж байна.

Өмнөх жилүүдийн парк ашиглалтыг дундаж хувь 90%-иас буураагүй ажиллаж ирсэн. Нийслэлийн Засаг даргын Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2020 оны А/1037 дугаар захирамж, 2023 оны А/940 дүгээр түр захирамжаар Замын хөдөлгөөнд тэгш сондгой улсын дугаараар оролцох чиглэлийн хүрээнд дугаарын хязгаартай өдрүүдэд тээврийн хэрэгслүүдийг үйлчилгээнд гаргахгүй байх зэрэг цаг үеийн шинжтэй ажлыг зохион байгуулснаар парк ашиглалтын дундаж үзүүлэлт 2024 онд 85% болж буурсан үзүүлэлттэй байна

Цахим засаглал, ухаалаг хяналтын тогтолцоог хөгжүүлэх

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/789 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд UB ERP Дотоод удирдлагын системд "Дуудлагын автомашины захиалгын систем"-ийг шинээр нэвтрүүлэн ажиллаж байна. Жилийн дунджаар инженерүүдийн болон диспетчерийн утсаар 151, "Дуудлагын автомашин захиалгын систем" нэвтрүүлснээр ERP системээр 1034 дуудлага ирснээс

105 дуудлага нь захиалагч байгууллагын зүгээс цуцлагдан нийт 1185 дуудлага хүлээн авч үйлчиллээ.

Нийслэлийн хэмжээнд дуудлагын автомашин, замын хөдөлгөөний зураглал, байршлын орон зайн мэдээллийг бүрэн хамруулсан үйлдлийн болон хяналтын шинэ дэвшилтэт техник, техник, программ хангамж бүхий нэгдсэн системийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын автомашины захиалга, дуудлагын нийтлэг үйлчилгээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд тээврийн хэрэгслүүддээ CP5 төхөөрөмжийг Би Ти Жи Ти ХХК-тай гэрээ байгуулж суурилуулсан. CP5 төхөөрөмж суурилуулснаар автомашины зогсож байгаа болон явж байгаа төлөв, байршил, хотоос орох гарах хөдөлгөөн, ажилтан, албан хаагчийн болон тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, явсан байршлын түүхийг харах зэрэг давуу талтай юм.

Авто парк, техник тоног төхөөрөмжийн төлөв

Нийслэлийн Засаг даргын 2024 оны өдрийн А/56 дугаар захирамжаар тогтоогдсон тарифын дагуу 2024 оны 12 дугаар сарын 25-ны байдлаар нийт 86 тээврийн хэрэгслээр 53 байгууллагын 79 хэрэглэгчдэд болон хөдөө орон нутагт, гадаад дотоодын зочид төлөөлөгчдөд нийт 854,753 км зам явж үйлчилсэн байна.

Нийслэлийн Засаг даргын тамгын газар яармаг дахь Хангарди ордон руу шилжсэнтэй холбоотойгоор 2, 3 дугаар паркуудыг татан буулгаж, нисэхэд 15 машины багтаамж бүхий гараашид паркарлж байгаа.


Үүнтэй холбоотойгоор төв паркийн ачаалал ихэссэн нь шинэ паркийн хэрэгцээг зайлшгүй нэмэгдүүлж байна.

Байгууллагын нийт 86 тээврийн хэрэгслийг насжилт болон маркаар төрөлжүүлэн графикаар харуулав.

График1



График2



Хүний нөөцийн чадавх ба ёс зүйг бэхжүүлэх

Байгууллагын бүтэц, орон тоо нь Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагддаг бөгөөд хамгийн сүүлд 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Нийслэлийн Засаг даргын А/614 дугаар захирамжаар тус байгууллагын бүтэц, орон тооны хязгаар шинэчлэгдсэн. Үүнд:

Хүснэгт 4

Хэлтэс		Орон тоо
1	Дарга	1
Захиргаа, хүний нөөцийн хэлтэс		9
1	Хэлтсийн дарга	1
2	Эрх зүйн асуудал хариуцсан ажилтан	1
3	Хүний нөөцийн ажилтан	1
4	Мэдээлэл технологи, архив бичиг хэргийн ажилтан	1
5	Үйлчилгээний ажилтан	1
6	Манаач	1
Санхүү, төлөвлөлтийн хэлтэс		3
1	Хэлтсийн дарга	1
2	Эдийн засагч, нягтлан бодогч	1
3	Техникч-нярав	1
Тээвэр, зохицуулалтын хэлтэс		92
1	Хэлтсийн дарга	1
2	Ашиглалтын инженер	1
3	Механик инженер	1
4	Диспетчер-механик	8
5	Үйлчилгээний жолооч	78
6	Механик засварчин	2
7	Сантехникч	1
Хэлтэс 3, нийт албан хаагчийн тоо 105.		Нийт 105

Дээд байгууллагаас зохион байгуулсан болон холбогдох мэргэжлийн байгууллагуудын сургалт хөтөлбөрт ажилтан, албан хаагчдаа тогтмол хамруулан, ур чадвар, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэхийг зорин ажилладаг.

2024 оны байдлаар байгууллагын хэмжээнд нийт 74 үйлчилгээний жолоочийн 61% буюу 48 нь мэргэшсэн жолооч байна.

Жил бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсээс зохион явуулдаг сургалтууд, Удирдлагын академитай хамтран зохион байгуулдаг сургалтад чиглэлийн дагуу захиргааны ажилтан, албан хаагчдаа бүрэн хамруулдаг.

Мөн Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын ажилтан, албан хаагчид гамшгийн зарлан мэдээллийн дуут дохиогоор дадлага сургуулилтыг тогтмол хийж, Нийслэлийн Онцгой байдлын газрын дэргэдэх сургалт үйлчилгээний төвийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх сургалт хөтөлбөрт хамрагддаг.

Авлигатай тэмцэх газар, Ёс зүйн хороотой хамтран "Төрийн албан хаагчийн ёс зүй" "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтад ажилчдаа хамруулж, хуулийн хүрээнд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, мэдээлэл танилцуулга хүргэдэг.

Архивын ерөнхий газраас зохион байгуулдаг сургалтууд, "Гэмт хэрэг, зөрчлийн тухай ойлголт, урьдчилан сэргийлэх арга зам" гэх мэтчилэн мэргэжлийн онцлогт суурилсан салбарын сургалт, семинарт холбогдох мэргэжилтэнг оролцуулан ур чадвар, мэдлэг боловсролыг нь нэмэгдүүлж, шинэ үе, шинэ нийгэмтэй хөл нийлүүлэн ажиллахад анхаарч байна.

Захиргааны албан хаагчид өөрсдийн мэргэжлийн дагуу сургалт судалгаанд хамрагдах боломжтой боловч үйлчилгээний жолооч, механик-засварчин, диспетчер-механикуудаа хамруулах сургалт ховор, сургалтын төлбөр өндөр, ажлын онцлогоос хамаарч практик дадлага хийх боломж муу зэрэг хүндрэлтэй асуудлууд тулгардаг.

Гэсэн хэдий ч бид жилдээ 1-2 удаа замын хөдөлгөөний дүрэм, бусад холбогдох сургалтыг явуулснаар 2023 онд замын хөдөлгөөний зөрчилтэй 51 жолооч 3,3 сая төгрөгийн торгуультай байсан бол 2024 онд замын хөдөлгөөний зөрчилтэй 49 жолоочийн 1,835,400 төгрөгийн торгуулийг төлүүлж, 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар манай байгууллага торгуульгүй байна. Үүнээс үзэхэд байгууллагын үйлчилгээний жолооч нарын сахилга хариуцлага сайжирч байгааг харуулж байна.

Иймд инженер техникийн ажилтнуудад чиглэсэн сургалт зохион байгуулдаг мэргэжлийн төвүүдтэй хамтарч ажиллах, ажилчдаа хамруулах нь чухал юм.

Санхүү, эдийн засгийн төлөв

Нийслэлийн Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/01 дүгээр "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" захирамжийн 1 дэх заалтад "Нийслэлийн төсвийн байгууллага, өмчит үйлдвэрийн газрын 2015 оны Санхүүгийн жилийн анхны дансны гүйлгээ хийгдэх хугацаанаас эхлэн шилэн дансны мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж, ажиллахыг Нийслэл, дүүргийн бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай" гэж заасны дагуу хийх ажлын төлөвлөгөө гарган батлуулж Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавигдах

мэдээллийн агуулга, стандарт, журмын дагуу холбогдох мэдээллийг байршуулж ажиллаж байна.

Газрын дарга 2024 онд ажилтан албан хаагчдын цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлэх талаар санхүү төлөвлөлтийн хэлтэст өгсөн үүрэг даалгаврын дагуу 3 үе шаттайгаар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байсан 2024 оны хувьд 4 дүгээр сард 5%-11%, 5 дугаар сард цалин хөлсний доод хэмжээ 19%, 6 дугаар сард хоолны мөнгийг 34,000 төгрөг хүртэл тус тус нэмэгдлүүдийг төсөвт суулгуулан ажилласан .

2024 оны 11 дүгээр сарын байдлаар нийт ажилтан албан хаагчдыг цалин өмнөх 2023 онтой харьцуулахад 30%-иар өссөн байна.

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газраас ирүүлсэн 05/2961 тоот албан бичгийн дагуу арилжааны банкин дахь дансыг хааж, Монгол банканд байрших Төрийн сангийн бүртгэлийн дансанд 2024.07.01-ны өдрөөс эхлэн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэн 2024 оны төсвийн тодотголд үйл ажиллагааны орлого, зардлын хуваарийг боловсруулж батлуулан ажиллаж байна.

Байгууллагын хөрөнгийн ашиглалт хадгалалтад эд хариуцагчийн тавих хяналтыг сайжруулан, шинээр ажилд орсон буюу ажлаас чөлөөлөгдсөн ажилтан тус бүрийн эзэмшиж буй хөрөнгийг тухай бүрд бүртгэл хөтлөн баталгаажуулдаг.

Төсвийг хэмнэлттэй үр өгөөжтэй зарцуулах, төсвийн зардлыг хэмнэх талаар арга хэмжээ авч батлагдсан төсвийн хүрээнд зардлыг хэтрүүлэхгүй норм нормативыг баримтлан цахилгаан, дулаан, ус холбооны зэрэг ашиглалтын зардлыг бууруулах, автомашинуудын засвар үйлчилгээг хугацаанд нь хийн өмчийн ашиглалтыг сайжруулж, хяналт тавин ажиллаж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд албан ажлын тээврийн хэрэгслийн өдрийн лимитийг 40км гэж тогтоосонтой холбоотой орлогын төлөвлөгөөнд нөлөөлж байна.

Үүнтэй холбоотойгоор 2024 оноос үйл ажиллагааны орлого 8.1%-иар буурсан үзүүлэлт харагдаж байна. Түүнчлэн тээврийн хэрэгслийн насжилтаас хамааран үйл ажиллагааны орлогын 43,6%-ийг шатахууны зардал, 23,8%-ийг сэлбэг хэрэгслийн зардлууд эзэлж байгаа нь маш өндөр эрсдэл дагуулж, цаашид санхүүгийн хувьд алдагдалд орох, үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Өнөөгийн төлөвийн дүгнэлт:

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын засаглалын өнөөгийн төлөв байдлыг дүгнэвэл: сүүлийн жилүүдэд төрийн байгууллагын тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг тасралтгүй сайжруулах, хариуцлагатай, ил тод, үр ашигтай байгууллагын жишгийг төлөвшүүлэх чиглэлд тогтвортой ахиц дэвшил гаргаж иржээ.

Өнөөгийн төлөв байдлын үнэлгээ:

- Байгууллагын бүтэц зохион байгуулалт, хүний нөөцийн чадавх сайжирч байна.
- ERP систем, GPS төхөөрөмж нэвтрүүлэн цахим хяналт, удирдлага хэрэгжүүлж эхэлсэн.
- Авто паркийн насжилт өндөр, техникийн элэгдэл их, төлөвлөгөөт бус засвар олширсон.

- Шатахуун, сэлбэг хэрэгслийн зардал өндөр тул санхүүгийн хүндрэл үүсэх эрсдэлтэй.
- Үйлчилгээний чанар, хэрэглэгчийн сэтгэл ханамж өндөр түвшинд байна.

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ нь төрийн байгууллагуудад авто тээврийн үйлчилгээг найдвартай, чанартай хүргэж буй, цахим системийг нэвтрүүлэн ил тод, хяналттай үйл ажиллагаа явуулж буй байгууллага юм. Гэвч техникийн паркийн хуучралт, засварын зардлын өсөлт зэрэг санхүүгийн эрсдэл нэмэгдэж байгаа нь стратегийн шинэчлэл хийх зайлшгүй шаардлагыг бий болгож байна. Иймд 2025–2028 онд байгууллагын техник шинэчлэл, хүний нөөцийн хөгжил, цахим хяналтын тогтолцоог бүрэн төлөвшүүлэх стратеги боловсруулав.

Энэхүү стратегийн төлөвлөгөө нь 2025–2028 оны хугацаанд байгууллагын үйл ажиллагааг үр ашигтай, ил тод, хариуцлагатай, цахимжсан, дэвшилтэд технологи нэвтрүүлсэн, тогтвортой тогтолцоо бүхий үйлчилгээний байгууллага болгон төлөвшүүлэх зорилготой.

НАЙМ.2025-2028 ОНЫ СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАСАГЛАЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН 6 ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ

Стратегийн зорилго	Хүлээгдэж буй үр дүн	Хэрэгжилт ба арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн үе шат ба хариуцах бүтэц
1	2	3	4	5
Стратеги зорилго: Бид нэгдмэл багаар тэргүүлж стандарт соёлоор манлайлсан, чанартай үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэнэ.				
Стратегийн зорилт 1. <u>Үйлчилгээний чанар ба аюулгүй байдлыг сайжруулна.</u>	1.Тээврийн ослын тоо 20%-аар буурна 2.Техникийн бүрэн бүтэн байдлын үзүүлэлт 90%-д хүрнэ 3.Хэрэглэгчийн сэтгэл ханамж $\geq 95\%$ 4.Тээврийн хэрэгслийн зогсолт, эвдрэл багасна	1.Тээврийн хэрэгслийн насжилтыг бууруулах, шинэчлэх үе шаттай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх 2.Техникийн бүрэн бүтэн байдлыг хангах засвар, оношилгоог графикаар хянах цахим систем нэвтрүүлэх 3.Үйлчилгээний жолооч нарт мэргэшүүлэх сургалт, аюулгүй байдлын зөвлөмж, сургалт тогтмол зохион байгуулах 4.Үйлчилгээний стандартыг шинэчлэн баталж, хэрэглэгчийн үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх	1.Автомашинны техникийн бүрэн байдлын хувь (%) 2.Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин (%) 3.Зам тээврийн ослын тоо (жилд)	2025:Шинжилгээ, стандарт тодорхойлох 2026:Сургалт, Техник хяналтын шинэчлэл 2027–2028:Нэгдсэн хяналт, Гэрээний чанар, Хэрэглэгчийн үнэлгээ Тээвэр, зохицуулалтын хэлтэс Санхүүгийн төлөвлөлтийн хэлтэс Захиргаа хүний нөөцийн хэлтэс, дотоод хяналт шалгалт

1	2	3	4	5
<u>Стратегийн зорилт 2.</u> Цахим засаглал, ухаалаг хяналтын тогтолцоог хөгжүүлнэ.	1.Захиалга, хариу өгөх хугацаа 30%-иар буурна 2.Хяналтын үр ашиг дээшилж, зам ашиглалт оновчтой болно 3.Ил тод байдал, хариуцлагын тогтолцоо бэхжинэ.	1.ERP системд автомашин захиалгын процессыг бүрэн шилжүүлэх 2.Автомашин бүрт GPS төхөөрөмж суурилуулж, хөдөлгөөн хянах 3.Байршил, шатахуун, жолоочийн хэрэглээний дата-г бодитоор цуглуулах	1.Автомашин техник бүрэн байдлын хувь (%) 2.ERP системд бүртгэгдсэн захиалгын тоо 3.GPS төхөөрөмжөөр хянагдаж буй тээврийн хэрэгслийн хувь (%) 4.Цахим захиалга-биелэлтийн дундаж хугацаа (минут)	2025:Систем өргөтгөх 2026:Цахим бүртгэл, тайлагнал 2027–2028: Интероперабел байдлыг хангах Мэдээллийн технологийн ажилтан Захиргаа хүний нөөцийн хэлтэс Тээвэр зохицуулалтын хэлтэс
<u>Стратегийн зорилт 3.</u> Авто парк, техник тоног төхөөрөмж, ногоон шийдэлд шилжинэ.	1.Байгууллагын авто парк техник шинэчлэгдэж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө буурна. 2.Шатахуун, сэлбэгийн зардал 10–20%-иар буурна. 3.Байгууллагын “ногоон бодлого”-ын хэрэгжилт дээшилж, олон улсын стандарттай нийцэх суурь тавигдана. 4.Цахилгаан тээврийн хэрэгсэлд дэд бүтэц (цэнэглэгч, тусгай гарааш, засварын тоног төхөөрөмж) бүрдэнэ. 5.Засварын давтамж, гэнэтийн эвдрэл буурна.	1.Насжилт өндөртэй, элэгдэл өндөртэй авто машин, тоног төхөөрөмжийг үе шаттай хасах төлөвлөгөө боловсруулах 2.Цахилгаан тээврийн хэрэгсэлд тохирсон дэд бүтцийг (цэнэглэгч станц гэх мэт) байгуулах саналыг танилцуулах 3.Утаа бага ялгаруулдаг, шатахуун хэмнэдэг хөдөлгүүртэй техник хэрэгсэл нэвтрүүлэх 4.Техникийн шинэчлэлд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусгуулах, төсөл хөтөлбөрт хамруулах	1.Насжилт өндөртэй автомашины хувь (%) 2.Ногоон тээврийн хэрэгслийн эзлэх хувь (%) 3.Ногоон тээврийн хэрэгслийн эзлэх хувь (%) 4.Цахилгаан машин цэнэглэгч суурилуулсан тоо 5.Хасагдсан хуучин тээврийн хэрэгслийн тоо	2025:Техникийн дүн шинжилгээ 2026:Туршилтын авто парк 2027–2028:Шинэ парк бүрдүүлэх Тээвэр, зохицуулалтын хэлтэс Санхүүгийн төлөвлөлтийн хэлтэс Захиргаа хүний нөөцийн хэлтэс

1	2	3	4	5
<u>Стратегийн зорилт 4. Хүний нөөцийн чадавх ба ёс зүйг бэхжүүлнэ.</u>	1.Мэргэшсэн жолоочийн хувь 80% давна 2.Зөрчил, торгууль 30%-иар буурна 3.Хамт олны эерэг уур амьсгал бэхжинэ	1.Үйлчилгээний жолооч, диспетчер механик, механик засварын ажилтнуудад мэргэжлийн сургалт зохион байгуулах 2.Ёс зүйн сургалт, ёс зүйн кодекс батлах 3.Урамшуулал, шагналын системийг тогтмолжуулах	1.Мэргэшсэн жолоочийн хувь (%) 2.Ёс зүйн сургалтад хамрагдсан ажилтны тоо 3.Зөрчил, сахилгын арга хэмжээний тоо	2025:Ёс зүйн сургалт Шинэ үнэлгээ, урамшууллын систем хэрэгцээ тодорхойлох 2026:Сургалт, шагналын шинэ систем 2027–2028: Тогтмол үнэлгээ Захиргаа хүний нөөцийн хэлтэс Хэлтсийн дарга нар Оролцогч талууд
<u>Стратегийн зорилт 5. Эрсдэл, дотоод хяналтын системийг боловсронгуй болгоно.</u>	1.Санхүүгийн болон тээврийн эрсдэл буурах 2.Алдаа, зөрчлийг эрт илрүүлж урьдчилан сэргийлнэ 3.Тайлагнал, хяналт ил тод болно	1.Эрсдэлийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх 2.Шалгалт, аудитын үйл ажиллагааг сайжруулах 3.Даатгал, хариуцлагын гэрээг шинэчлэх	1.Эрсдэлийн үнэлгээ хийсэн тоо (жилд) 2.Шалгалт, аудитаар илэрсэн зөрчлийн тоо 3.Даатгалд хамрагдсан автомашины хувь (%)	2025:ХШҮ систем боловсруулалт 2026:Тайлагнал шинэчлэх 2027–2028:Аудит, ил тод байдал Дотоод хяналт, ХШҮ Бүх хэлтэс
<u>Стратегийн зорилт 6.1 Зорилго, алсын хараа, стратегийг сайжруулна.</u>	1.Байгууллагын стратегийн уялдаа сайжирна 2.Удирдлагын шийдвэр гаргалт үр дүнтэй болно 3.Албан хаагчдын оролцоо, хариуцлага нэмэгдэнэ	1.Байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлсийг тодорхой болгох 2.Алсын хараа, стратегийг ажилтан бүрт танилцуулах 3.Гүйцэтгэлийн үнэлгээ, KPI систем нэвтрүүлэх	1.Албан хаагчдын стратегийн мэдлэгийн үнэлгээ (%) 2.KPI гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн 3.Стратегийн уялдаа бүхий үйл ажиллагааны тоо	2025: Алсын харааг таниулах 2026: Үнэт зүйл сургалт 2027–2028: Брэнд, олон нийттэй харилцах Захиргаа хүний нөөцийн хэлтэс

1	2	3	4	5
6.2.Байгууллагын соёл ба манлайллыг хөгжүүлнэ.	1.Эерэг уур амьсгал, өндөр хариуцлагатай хамт олон 2.Удирдлагын манлайллын чанар сайжирна	1.Үнэт зүйлсийг тодорхойлж тунхаглах 2. Манлайллын сургалт, соёлын хөтөлбөр 3.“Манлайлагч ажилтан”-ы систем	1.Ажилтны сэтгэл ханамж $\geq 80\%$ — 2.Манлайллын сургалтад хамрагдсан хүний тоо 3.Соёлын өдөрлөгийн жил тутмын хэрэгжилт	2025–2028: Захиргаа хүний нөөцийн хэлтэс
6.3.Оролцогч талуудыг оролцоог хангана.	1.Идэвхтэй оролцоо 2.Харилцан ойлголцол, итгэлцэл нэмэгдэнэ	1.Санал асуулга тогтмол зохион байгуулах 2.Нээлттэй хяналт, зөвлөлдөх форум ажиллуулах	1.Хэлэлцүүлэгт оролцогчийн тоо 2.Санал гомдлын шийдвэрлэлт $\geq 90\%$	2025–2028: Бүх хэлтэс
6.4.Тогтвортой үнэ цэнийг бий болгоно.	1.Ажлын уур амьсгал нэг хэв шинжтэй болно 2.Үнэт зүйлд суурилсан үйл ажиллагаа тогтноно	1.Үнэт зүйлсийг хэрэгжүүлэх гарын авлага, сургалт 2.Ажлын байран дээр хэрэгжилтийн хяналт	1.Үнэт зүйлсийг мэддэг, мөрддөг ажилтны хувь $\geq 95\%$ 2.Холбогдох бодлогын баримт бичиг шинэчлэгдсэн байх	2025-2028: Бүх хэлтэс
6.5.Гүйцэтгэл ба өөрчлөлтийн удирдлагыг сайжруулна.	1.Ажлын үр дүн тодорхой, хариуцлагын тогтолцоо бий болно	1.KPI тогтоох 2.Гүйцэтгэлийн үнэлгээ, тайлагнал 3.Өөрчлөлтийн менежментийн сургалт	1.KPI хэрэгжилтийн түвшин $\geq 90\%$ 3.Гүйцэтгэлийн үнэлгээ тогтмол хийгддэг байх	2025–2028: Захиргаа хүний нөөцийн хэлтэс
6.6.Оролцогч талуудын сэтгэл ханамж, ойлголтыг дээшлүүлнэ.	1.Идэвхтэй харилцаа 2.Сэтгэл ханамжтай оролцогч талууд	1.Сэтгэл ханамжийн судалгаа 2.Сайжруулалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	1.Судалгааны хамрах хүрээ $\geq 80\%$ 2.Сэтгэл ханамжийн индекс $\geq 85\%$	2025–2028: Бүх хэлтэс Ажлын хэсэг Оролцогч талууд
6.7.Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулна.	1.Үр дүнд суурилсан удирдлага төлөвшинө	1.Төлөвлөлтийн систем шинэчлэх 2.Үйл ажиллагааны гүйцэтгэлийг стратегитай холбох	1.Стратеги болон үйл ажиллагааны уялдаа $\geq 90\%$ 2.Сарын тайлан, хяналт үр дүнтэй байх	2025 оноос жил бүр Бүх хэлтэс Ажлын хэсэг

ДҮГНЭЛТ:

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг үндэслэн, уялдуулан боловсруулсан.

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын 2025–2028 оны стратегийн төлөвлөгөө нь байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулж, техник технологийн шинэчлэл, хүний нөөцийн хөгжил, дотоод хяналт, ногоон шийдэлд суурилсан хөгжлийг хангахад чиглэлээ.

Стратеги төлөвлөгөөнд дараах 6 үндсэн зорилт, тэдгээрийн хэрэгжилтийн үе шат, хариуцсан бүтэц, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон нь хэрэгжилтийн үр дүнг тооцох, хянах, үнэлэх тогтолцоог бий болгоход чухал ач холбогдолтой.

Ерөнхий үнэлгээ:

- Давуу тал: Шинэ технологи, инновацын дэмжлэгтэйгээр тогтвортой, аюулгүй, ил тод авто баазын тогтолцоог бүрдүүлэх стратеги нь байгууллагын хөгжлийн цөм болж байна.
- Сул тал: Санхүүгийн эх үүсвэр, хуучин тээврийн хэрэгслийн элэгдэл, хүний нөөцийн сургалтын хүрэлцээ муу зэрэг нь зарим зорилтыг хэрэгжүүлэхэд саад учруулж болзошгүй.
- Боломж: Хотын удирдлагын дэмжлэг, бодлогын уялдаа, олон улсын туршлагыг нутагшуулах зэргээр төлөвлөгөөний амжилтыг хангах боломжтой.
- Эрсдэл: Санхүүжилтийн хомсдол, ногоон шилжилтийн хөрөнгө оруулалтын өндөр өртөг.

Энэхүү стратегийн төлөвлөгөө нь байгууллагын дотоод үйл ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлж, Нийслэлийн төр захиргааны авто бааз УТҮГ-ын тогтвортой, үр ашигтай, байгальд ээлтэй хөгжлийн үндсийг тавих бодит суурь баримт бичиг болгохоор зорилоо. Төлөвлөсөн ажлуудыг үе шаттайгаар, тодорхой шалгуур үзүүлэлттэйгээр хэрэгжүүлснээр байгууллага чанартай, найдвартай, хэрэглэгчдэд чиглэсэн төрийн тээврийн үйлчилгээг хөгжүүлэх бүрэн боломжтой байна.